

СОЛОНГОСЫН ХОЙГ ДАХЬ НААШТАЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

*Н.Дангаасүрэн**

Ц.Баатар'

НЭГ. ТҮҮХЭН ТОЙМ

Солонгосын хойг эртнээс Хятад, Япон гэсэн хоёр хүчирхэг гүрнийг холбогч гүүр, дорнын соёлыг түүчээлэн түгээх "алтан гурвалжин"-ы үүрэг гүйцэтгэж ирсэн билээ. Хятад, Япон хоёр энэ хойгийг хянах сонирхлоо түүхийн аль ч үед орхиогүй. Болж л өгвөл бие биенээсээ өрсөн дангаараа ноёрхлоо тогтоохыг эрмэлзэж байв. МЭӨ 108 оноос хойш бараг 400 гаруй жил Хятад Солонгосын хойгийн зарим хэсгийг хянаж байлаа. Тэр цагаас хойш Япон ч гэсэн зүгээр харж суусангүй. Газар нутгийн маргаан тасралтгүй үүсгэж, хойгийн зарим хэсэгт хяналт тогтоохыг санаархсаар ирсэн гэж түүхэнд тэмдэглэжээ.¹ Солонгос Японы түрэмгийллээс сэргийлэх үүднээс Хятадтай нэлээд ойр холбоотой явж иржээ. 1894-1895 онд болсон Солонгос Японы дайнд Солонгос ялагдал хүлээв. 1910 он гэхэд Япон Солонгосын хойгт бүрэн хяналтаа тогтоож, 1945 он хүртэл колони маягаар захирч байлаа. 1945 онд Дэлхийн II дайн дуусч, Солонгосын хойг хоёр хэсэгт хуваагдлаа. Орос /хуучнаар ЗСБНХУ/ Умардыг, Америк Өмнөдийг хянах болжээ. 1950-1953 оны солонгос хоорондын дайнд 4 сая гаруй хүн амь үрэгдсэн нь түүхийн хамгийн эмгэнэлт үе байлаа.² Нийт үндэстний эмгэнэлийн дараа эвлэрэх нь бүү хэл дайсагналцах нь ихэсч улмаар их гүрнүүдийн хяналтын дор Өмнөд, Умард Солонгос гэсэн хоёр улс байгуулагдсан түүхтэй. Тэр цагаас хойш Солонгосын хойг Азийн, Дэлхий нийтийн анхаарал татсан хүйтэн дайны голомт газар нутаг, Зүүн хойт Азийн бүс нутгийн аюулгүй байдал, хамтын ажилгаанд саад тогтор болсон бул хар чулуу, элдэв болохгүй, бүтэхгүй, маргаантай асуудлын архагшсан үүр уурхай цөм гэгдэн дэлхий нийтэд адлуулсаар ирэв. Энэ бүхний гол буруутан, хэргийн эзэн нь Хойт Солонгос болсоор ирсэн.

Солонгос хоорондын өнгөрсөн хагас зуу гаруй жилийн харилцааны түүхэнд хоёр улс үндсэн асуудлаар зөвшилцэлд хүрч байсан удаагүй. Гэсэн хэдий ч хоёр тал янз бүрийн түвшинд яриа хэлцэл явуулсаар ирсэнийг тэмдэглэх нь зүйд нийцнэ. Энэ чиглэлээр болсон зарим онцлог үйл явдлыг хураангуйлан товч өгүүлье.

1972 он: Хоёр тал эвлэрлийн Гэрээ байгуулж, харилцааг

*Н.Дангаасүрэн - Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор

'Ц.Баатар - Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, (Ph.D)

хэвийн болгохын тулд аль аль нь хүчин чармайлт гаргасан боловч үр дүнд хүрээгүй. Тухайн үед тэд өөр өөрсдийн байр суурийг хатуу баримталж бие биедээ хүлээж авахын аргагүй хатуу болзол тулгаж, заримдаа зөрүүдэлж байсан нь харилцааг улам хөндийрүүлсэн.

1983 он: Умардад айлчилж байсан Өмнөд Солонгосын Засгийн газрын дөрвөн сайд тэргүүтэй төлөөлөгчид дэлбэрэлтэд өртөж амь үрэгдсэн нь хоёр Солонгосын харилцааг улам ч хурцатгав. Үүний гол буруутан нь мөн л Умард Солонгос болсон.

1988 он: БНСУ, БНАСАУ-тай худалдаа арилжааны холбоо тогтоохыг зөвшөөрлөө.

1990 оны есдүгээр сар: Хоёр Солонгосын Ерөнхий сайд нар товлоогүй уулзалт хийлээ.

1991 оны арван хоёрдугаар сар: Хоёр тал бие бие рүүгээ халдахгүй байх гэрээ байгуулсан ч тус болоогүй.³

Умард Солонгосын ерөнхийлөгч Ким Ир Сенийг амьд сэрүүн байх үед хоёр орны тэргүүн нарын уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөж, энэ хүрээнд хийх бэлтгэл ажил нь ч үндсэндээ хангагдсан байлаа. Гэвч 1994 онд БНАСАУ-ын удирдагч таалал төгсч хоёр улсын харилцаа эргээд л зогсонги байдалдаа орсон юм.

ХОЁР. СОЛОНГОС ХООРОНДЫН ЭВЛЭРЛИЙН ЭХЛЭЛ

Дэлхий дахинаа "Солонгосын Н.Мандела" хэмээгдэн алдаршсан, хүний эрх, ардчиллын төлөө цогтой тэмцэгч домогт эр Ким Дэ Жүн 1997 онд БНСУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдлоо. Ингэснээр БНСУ дэлхийн ардчилсан орнуудын эгнээнд багтан орох эргэлтийн үеийг авчирсан. Түүнээс хойш тэрбээр БНСУ-д ардчилсан тогтолцоог бэхжүүлэх, ард түмнийхээ эв нэгдлийг бэхжүүлэхийн төлөө асар их хүчин чармайлт гарган, өөрөөсөө шалтгаалах бүхнийг хийж, хичээн зүтгэсээр байна. Ким Дэ Жүн Ерөнхийлөгчийн албанд томилогдсоноосоо хойш Умард Солонгосын талаар эвлэрэл хамтын ажиллагаанд үндэслэсэн "Нарны элчийн бодлого" (Sunshine policy) – ыг үе шаттайгаар зугуухан хэрэгжүүлж эхэлсэн.

Умард Солонгосын ард түмний амьд шүтээн болсон их удирдагч Ким Ир Сен 1994 оны долдугаар сард таалал төгсч, хүү Ким Чен Ир БНАСАУ-ын удирдагчын суудлыг өвлөв. Тэрбээр нэг хэсэг эцгийн сургаал "Чучхэ"–д үнэнч байхаа тангараглаж, Умард Солонгосыг дэлхий ертөнцөөс тусгаарлагдмал хэвээр байлгах гэж нэлээд үзсэн. Дэлхий дахинаа түүнийг маш хаалттай ёс суртахуун баримталдаг, олонд харагддаггүй, зожиг нуугдмал амьдралтай, хаалттай улсын зард гарсан хаалтай тэргүүн гэж үздэг байлаа. Гэвч энэ эрхэм удирдагч ухаантай хүн учраас өнгөрсөн хугацаанд улс төрийн хувьд асар

хурдан боловсорч үзэл бодол, байр суурь, имижээ аажмаар өөрчилж эхэлсэн. Түүний өөрийнх нь өгүүлснээр 1979 оноос Өмнөдийн TV байнга үзэж, сонин сэтгүүлийг унших болсон⁴ нь Өмнөдийн төр, олон нийт Умардынхантайгаа ойртохын тулд хичнээн их хичээл зүтгэл гаргаж байгааг бодитойгоор ойлгоход нь ихээхэн түлхэц өгч, дээд хэмжээний уулзалтын нэг талын бэлтгэл болсон бизээ. Нөгөө талаар Умард Солонгос дэлхий нийтийн хөгжлийн хандлагын эсрэг хичнээн сөрөн зогсох тусам дэлхийн нийтийг хамарсан глобальчлалын үйл явцаас төдий чинээ хол хоцрохыг тэр эрхэм удирдагч ойлгосон. Ингээд тэрбээр 1998 онд БНАСАУ-ын Үндсэн хуулинд зах зээлийн эдийн засгийн шинжтэй зарим өөрчлөлтийг өөрөө санаачлан оруулж, дэлхий нийтийн харилцааны өнөөгийн хандлаганд нийцүүлэн өөрийн өвөрмөц байдалдаа тохирсон гадаад бодлогын нааштай шинэлэг алхмууд хийж эхэлсэн. БНАСАУ гадаад бодлогодоо юуны өмнө өрнөдийн орнуудтай харилцаагаа сэргээж Япон, АНУ, Канад, Итали, Филиппин, Австрали болон Европын орнуудтай харилцаагаа сайжруулах оролдлого хийж, бүс нутаг, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах чиглэлээр санал санаачлага гаргасаар байна. Үүнтэй холбогдуулан хэлэхэд чухамдаа дээрхи орнуудын төр засгийн тэргүүнүүд л БНАСАУ-ын удирдагч Ким Чен Ир-т Ким Дэ Жүний "Нарны элч" бодлогыг дэмжихэд ихээхэн урам зориг оруулсан нь дамжиггүй. Хоёр талын эдгээр бодит хүчин чармайлт, Умардынханы эдийн засгийн эрэлт хэрэгцээ асар их байсан зэрэг олон хүчин зүйлүүд нь Умард Солонгос Өмнөд Солонгостой хэлэлцээ хийж, энх тайвны гэрээ байгуулахад хүргэсэн гэж үзэж болох юм.

Ийнхүү хоёр талын бодит хүчин чармайлтын үр дүнд эвлэрлийн эхлэлийг тавьсан Солонгосын хойг төдийгүй дэлхий нийтийн томоохон ач холбогдол бүхий түүхэн үйл явдал болох хоёр Солонгосын дээд хэмжээний уулзалт өнгөрсөн оны зургаан сард болж өнгөрлөө.

БНАСАУ-ын нийслэл Пхеньянд БНСУ-ын Ерөнхийлөгч Ким Дэ Жүн, БНАСАУ-ын Батлан хамгаалах хорооны дарга Ким Чен Ир нар Дээд хэмжээний уулзалт хийж, Солонгосын хойгийн түгшүүртэй байдлыг намжаах хоёр Солонгосыг нэгтгэх чиглэлд хамтран ажиллах тухай гэрээнд гарын үсэг зурсан билээ. Дэлхий дээрх хамгийн их цэрэгжсэн бүсэд тооцогдож буй хилийн шугамаар хуваагдсан Солонгосын хойгийн түгшүүртэй байдлыг намжаах, хоёр улсыг алсдаа нэгтгэх, тус тусдаа амьдарч байгаа гэр бүл, ах дүүсийг уулзуулах, Өмнөд Солонгосоос Умард Солонгост оруулах хөрөнгө оруулалтыг оролцуулан хоёр орны нийгэм, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг олон асуудал уг гэрээнд тусгагдсан юм. Түүнчлэн хоёр орны төрийн тэргүүн нар уулзалт хэлэлцээндээ Өмнөд, Умард

хоёр талын хүчин чармайлтаар энх тайвны замаар улсаа нэгтгэх, хамтарч ажиллах чиглэлээр хэлэлцэн тохиролцсон бөгөөд үүнийгээ нэн даруй хэрэгжүүлэхийн тулд хэлэлцээр хийхээр тодорхой саналуудыг ч дэвшүүлсэн. Түүнчлэн Солонгосын хойгийн асуудлаар талуудын шийдвэрлэх зарчмын асуудлууд, мөн дахин дайн гарахаас сэргийлэх, улс үндэстэнээ нэгтгэх арга замын адил талыг хүлээн зөвшөөрөх, хоёр улсын нутагт салангид амьдарч байгаа гэр бүл, ахан дүүсийн асуудлыг шийдвэрлэх, олон талт харилцаа, хамтын ажиллагаа зэрэг асар өргөн цар хүрээтэй цогцолбор асуудлыг хөндөн хэлэлцэж харилцан тохиролцоонд хүрсэн нь хоёр Солонгосын харилцааны хөгжилд маш чухал ач холбогдолтой түүхэн үйл явдал боллоо. Энэ үеэр хоёр тал хэлэлцэн тохиролцсон зүйлүүдээ цаг хугацаа алдахгүйгээр бодит ажил хэрэг болгон хэрэгжүүлж эхлэх нь зүйтэй гэж үзээд цаашид уулзалт яриа хэлэлцээг янз бүрийн түвшинд тогтмолжуулахаар санал нэгтэй тогтлоо.

Солонгосын хойг хоёр хэсэгт салан тусгаарлагдсанаас хойш анх удаа төрийн тэргүүн нарын уулзалт хэлэлцээ ийнхүү амжилттай болж, таван зүйл бүхий хамтарсан тунхаг бичиг гаргасан нь хоёр Солонгосын эвлэрэл, хамтын ажиллагааны шинэ үеийн эхлэл болон өнгөрсөн зууны төгсгөлийн түүхэнд бичигдлээ.

БНСУ-ын Ерөнхийлөгч Ким Дэ Жун дээд хэмжээний уулзалтаас хоёр Солонгос цаашдаа эвлэрэл, нэгдэлд хүрнэ гэсэн итгэлтэй буцаж ирсэнээ мэдэгдсэн ⁵.

Дэлхий нийтийн анхаарлын төвд байсан дээд хэмжээний уулзалт хоёр Солонгосын харилцааны шинэ эрин, энх тайвны төлөө хамтадаа ургашлахын дохио боллоо.

АНУ-ын экс Ерөнхийлөгч Б.Клинтон дээд хэмжээний уулзалтад чин сэтгэлээсээ талархаж байсан бол Японы Ерөнхий сайд асан Ё.Мори уг үйл явдлыг Берлиний хана нурсантай зүйрлэн хэлжээ. Орос, Хятад, Монгол зэрэг Зүүн хойт Азийн орнуудын төр засгийн тэргүүн нар ч дээд хэмжээний уулзалтын үр дүнг сайшаан тэмдэглэж, Солонгосын хойгт эвлэрч хамтран ажиллах үйл явц цаашид өрнөнө хэмээн найдаж байгаагаа илэрхийлжээсэн билээ.

ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ӨРНӨЛ

Солонгосын хойгт үйл явдал өнөөдөр хэний ч төсөөлөөгүй хурдаар өрнөж байна. Хоёр Кимийн дээд хэмжээний уулзалтын дараа Солонгос хоорондын харилцаа харьцангуй сайжирч, тохиролцсон яриа хэлцэлүүд ямар нэг онцын саад бэрхшээлгүйгээр хоёр талын хүчин чармайлтын үр дүнд бодит ажил хэрэг болж биелэлээ олсоор байна. Тухайлбал, өнгөрсөн оны наймдугаар сард Солонгосын

дайнаар хилийн наана, цаана хоцорсон ах дүүсийн өчүүхэн хэсэг болох зуу зуун хүмүүс хоёр талдаа харилцан айлчилж ах дүүстэйгээ 50 жилийн дараа анх удаа нүүр тулан уулзалдлаа. Есдүгээр сарын эхээр Өмнөд Солонгост тагнуул хийсэн хэргээр 13-45 жил суусан 66-90 насны 63 хүнийг Өмнөд Солонгосын Засгийн газар шоронгоос суллан Умард Солонгос руу гэр оронд нь буцаалаа. Нэг үндэстэний хоёр улс "Сидней-2000" олимпийн нээлтэд анх удаа нэгэн тугийн дор зэрэгцэн жагсаж дэлхий нийтийн талархал хүлээв. Түүний дараахан хоёр Солонгосын Батлан хамгаалах яамны сайд нарын уулзалт боллоо. Уулзалтаар хил дээрээ тус тус хоёр сая орчим цэрэг, аль алиных нь нийслэл хотод хүрэх чадалтай их буу, пуужин байрлуулсан минижүүлсэн талбай бүхий дэлхийн хамгийн их цэрэгжүүлсэн энэ бүс нутагт дүрэлзэн асч болзошгүй дайны аюулыг намжаахад хамтран ажиллах асуудлыг голлон хэлэлцэж тодорхой тохиролцоонд хүрэв. Мөн хоёр улсыг холбох төмөр замыг барихад чухалд тооцогдож буй газрын тэсрэх бөмбөгийг цэвэрлэх асуудлыг ч хөндөн хэлэлцсэн аж. Энэ үеэр өмнөдийн нийслэл Сөүл хотод хоёр Солонгосын ажил хэрэгч хүмүүс уулзаж 22 сая хүн амтай умардын талд шаардлагатай байгаа хөрөнгө оруулалтын асуудлыг хэлэлцэж тодорхой тохиролцоонд хүрэв. Хоёр Солонгосын харилцаа хамтын ажиллагаанд итгэлцэлийг бэхжүүлэх, солонгос хоорондын харилцааг эрчимжүүлэхэд бэлэн байгаагийн илэрэл болгож хоёр Солонгосын нийслэлийг холбох төмөр зам барих асуудлыг шийдвэрлэв. Өмнөдийн тал зам барих нээлтийн ажиллагаанд асар их ач холбогдол өгч төрийн ёслолоор эхлүүлэв. Нээлтэд БНСУ-ын ерөнхийлөгч Ким Дэ Жүн гэргийн хамт оролцжээ. Мөн манайхаас тэнд суугаа Элчин сайд болон бусад орны Элчин сайдууд уригдав. Хойт Солонгосчууд мөн тэр өдөр, тэр цагт зам барих нээлтийн ёслол үйлдсэн байна.

Өмнөдийнхэн ийнхүү зам барих ажилдаа шуудран орлоо. 91 сая ам. доллараар босох энэ замыг солонгосчууд энх тайван найрамдлын бэлэг тэмдэг, хоёр улс нэгдэж нийлэхийн түлхүүр зам хэмээн нэрлэж буй аж. Энэ зам баригдах нь Берлины хана нурсантай эн тэнцэнэ гэж БНСУ-ын Ерөнхийлөгч Ким Дэ Жүн нээлтийн ёслол дээр мэдэгдлээ⁶. Одоогоос арав гаруй жилийн тэртээ Берлины хана нурсанаар хоёр Герман нэгдэх зам шууд тавигдсан билээ. Тэгэхээр энэ түүхт үйл явдал Солонгосын хойгт давтагдах цаг хугацаа нэг их хол биш ч байж болох. Түүнийг цаг хугацаа харуулах бизээ. Үүнийг "мятрашгүй" хэмээгдэгч Ким зөгнөж буй билээ. Хурдан галт тэрэгний энэ замыг энэ оны намар ашиглалтанд оруулахаар Өмнөдийн тал тооцоолж байна. Цаашдаа энэ зам Солонгосын хойгийг Зүүн өмнөд болон Зүүн хойд Азитай холбох аж. Энэ нь олон улсын хэмжээнд олон жил яригдаж, яриа хэлэлцээний хүрээнээс гарч чадаагүй Зүүн

хойт Азийн хамтын ажиллагаанд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх Түмэн голын төсөл амилах таатай нөхцөлийг бүрдүүлж байгаагаараа бүр ч их ач холбогдолтой юм. Энэ дашрамд тэмдэглэхэд одоо Зүүн хойд Азийн Банк байгуулах асуудал ид яригдаж байна. "Энэ нь хоёр Солонгосын нэгдэл, Монгол, ОХУ-ын Алс Дорнодод их нөлөөтэй байх болно" гэж Америкийн эрдэмтэн, Зүүн хойт Ази судлаач, Стефен Хоэрпер үзэж байна⁷.

Ийнхүү хоёр талаас дэлхий нийтийн талархал хүлээсэн зоригтой алхамуудыг хийсээр байна. Үүний ач үрээр Умардын нийгэм эдийн засгийн амьдралд ч нэлээд нааштай хандлага бий болж байгаа талаар дэлхий нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ам өрсөн мэдээлэх болов. Тэнд амьдрал дээшилж, үйлдвэрлэл нь есөн жилийн дараа буюу 2000 оны эцсээр анх удаа 6,2 хувиар өсчээ. Гэвч энэ нь харьцангуй ойлголт. Байдал бүүр дээрдсэн, санаа зовох юмгүй гэсэн үг биш нь ойлгомжтой. Ган гачиг нүүрлэсэн, ганцаардсан өмнөх есөн жилд хоёр сая хүн өвчин, өлсгөлөнгөөр үхсэн гэж НҮБ тооцсон байдаг.

Монгол болон БНАСАУ-д томилолтоор ажилласан НҮБ-ын тусгай төлөөлөгч хатагтай Каролин Мкэски НҮБ-ын төв байранд энэ оны нэгдүгээр сарын хорин дөрвөнд мэдээлэл хийлээ. Хатагтай Мкэскийн мэдэгдэж буйгаар БНАСАУ-д ажиллаж буй НҮБ-ын ажилтнууд маш хүнд нөхцөлд ажиллаж буй аж. Олон нийтийн үйлчилгээ гэж бараг үгүй, цахилгаан эрчим хүчийг маш хатуу нөхцөлтэй олгодог. Өвөлжилт нэлээд хүнд байгаа ч ихэнх байр барилга, орон сууцанд халаалт өгөөгүй байгаа гэнэ. Эмнэлгийн үйлчилгээ хүнд, эм тарианы хангалтыг олон улсын байгууллагын зүгээс үзүүлэх боловч хэрэгцээг нь бүрэн хангах ямарч боломжгүй аж. Аж үйлдвэрийн салбар дахь социалист орнуудтай тогтоосон харилцаа зогссоноос ажлын байрын тоо асар ихээр буурчээ. Засгийн газраас өгч буй тэтгэлэг нь дөнгөж амь зуух төдий. Олон хүн олон улсын байгууллагаас үзүүлж буй хүнсний тусламжаар амь зогоож буй ажээ.

НҮБ 2000 оны арваннэгдүгээр сарын сүүлээр БНАСАУ-д 400 сая ам. долларын тусламж үзүүлэхийг уриалсан байна. Үүний 380 сая нь Дэлхийн хүнсний хөтөлбөрөөр хүргэгдэх хүнсний тусламжид зарцуулах аж. Байдлыг газар дээр нь нүдээр үзэж, НҮБ-д албан ёсоор мэдээлэл хийсэн хүний үг ийм байна⁸.

Умардынханыг өлсгөлөн гачаалаас хагацахад Өмнөд Солонгос, АНУ, Япон ихэд тусалж байгаа билээ. Хүмүүнлэгийн чанартай энэ тусламжын зарим хэсэг нь хөрөнгө оруулалт, урт хугацааны зээллэг зэрэг дэлхийн глобаль эдийн засгийн харилцааны жишиг хандлага тийш чиглэж байна. Умардынхан ч улс орныхоо амьдралыг өөд нь татахад дан ганц гадаадын зээл тусламж харалгүй өөрсдөөсөө

шалтгаалах бүхнийг хийж байна. Энэ тал дээр хаа очиж манайхаас ч илүү овсгоо самбаатай ажиллаж эхэллээ. Тухайлбал, Макаогийн мөрийтэй тоглоомын эзэн Ста Энли Хэ 233 сая ам. долларын хөрөнгө оруулж Пхеньянд казино нээжээ. Одоо хоёрдахь казиног Хонконгийн зугаа цэнгэлийн тоглоом эрхлэгч Альберт Иенг Умардын Рашин- Сонбон хотод нээх болоод байна. Үүнд ноён Альберт Иенг 500 сая ам. доллар зарцуулах аж. Энэ мэтээр гадаадын хөрөнгө оруулалттай томоохон объектуудыг барьж байгуулахыг Умардынхан хөхүүлэн дэмжиж байна. Дээд хэмжээний уулзалтын дараа Өвөр Солонгосын бизнес эрхлэгчид Ар Солонгост шил шилээ даран очсоор байгаа тухай дэлхийн хэвлэлүүд бичиж байна. Өвөр Солонгосын зарим томоохон нэртэй компаниуд тэнд аль хэдийн салбараа нээжээ⁹.

Солонгос хоорондын эвлэрэл, хамтын ажиллагаа энэ хойгийн төдийгүй Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагаанд ихээхэн чухал ач холбогдолтой хэмээн Зүүн хойт Ази судлаачид, шинжээчид үзэж байна..

ДӨРӨВ. УМАРД СОЛОНГОСЫН ГАДААД БОДЛОГОД ГАРЧ БУЙ ЗАРИМ НААШТАЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Солонгос хоорондын харилцааны нааштай өрнөл нь Умард Солонгосын гадаад бодлогод ч өөрчлөлт шинэчлэлийн өнгө аяс орууллаа. Дээд хэмжээний уулзалтын дараа Умард Солонгост Оросын Ерөнхийлөгч В.Путин, Америкийн Төрийн нарийн бичгийн дарга асан М.Олбрайт нар Умард Солонгост айлчиллаа. Түүнээс хойш БНАСАУ, Америк, Япон болон Европын орнуудтай янз бүрийн түвшинд яриа хэлэлцээ хийлээ. Пхеньян Австрали, Канад, Итали, Европын зарим оронтой дипломат харилцаа тогтоолоо. Ийнхүү нэгэн үе "луйварчин" орнуудын тоонд орж байсан Умард Солонгосыг өнөөдөр дэлхий нийт анхааралтай ширтэн харж энэ орны талаар баримталж ирсэн бодлогоо эргэн харж эхэлсэн билээ. Тухайлбал, АНУ өнгөрсөн 50 жилийн турш БНАСАУ-ын эсрэг баримталж ирсэн эдийн засгийн хориг арга хэмжээгээ өнгөрсөн оны зургаадугаар сарын сүүлчээр албан ёсоор цуцаллаа. Цуцалж буй хязгаарлалтыг дурдвал:

- Умард Солонгосын үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн импорт;
- АНУ-ын компани, тэдгээрийн салбар цэгүүдийн үйлдвэрлэсэн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон ашиг орлоготой үйлчилгээний экспорт;
- Хөдөө аж ахуй уул уурхай, газрын тос, мод, цементийн тээвэрлэлт, зам, далайн боомт, онгоцны буудлын

байгууламж, аялал жуулчлалын салбар дахь хөрөнгө оруулалт;

- Америкийн иргэдээс Умард Солонгос руу мөнгө гуйвуулах асуудал;
- Умард Солонгосоос болон Умард Солонгос руу баталгаат ачааг Америкийн худалдааны хөлөг онгоц, нисэх онгоцоор тээвэрлэх;
- АНУ, БНАСАУ-ын хооронд худалдааны нислэг хийх зэрэг болно.¹⁰

Хэдийгээр хориг арга хэмжээг цуцалж нааштай алхам хийж байгаа ч БНАСАУ-ын тодорхой хэсэгт тогтоосон худалдааны буюу санхүүгийн хязгаарлалт хэвээр үлдэж байгаа юм. Энэ нь Умард Солонгос террорист ажиллагааг дэмждэг улс гэсэн тодорхойлолтонд хэвээр байгаатай холбоотой гэж "CNN" тайлбар өгчээ. Үнэн хэрэгтээ Пхеньянаас Солонгосын хойгийн хурцадмал байдлыг төгсгөл болгож, терроризмаас бүрэн татгалзаж байгаагаа үйл ажиллагаагаараа баталсан цагт дээрх хориггоо бүрэн цуцлахаа Вашингтон илэрхийлж байгаа билээ. Үүнтэй холбогдуулан дурьдахад Америкийн Зүүн хойт Азийн аюулгүй байдлын судлаачид Солонгосын хойгийн талаар харилцан адилгүй байр суурь баримталдаг. Тухайлбал, "Миний хувьд Зүүн хойт Азид хамгийн их халуун цэг бол олонхи хүмүүсийн ярьдагчлан Солонгосын хойг бус, харин Хятад, Тайванийн хэрэг явдал юм" гэж АНУ-ын тэнгисийн цэргийн чөлөөнд гарсан адмирал, Зүүн хойт Азийн аюулгүйн байдлын судлаач Э.Мак Валдон хэлсэн байдаг¹¹.

Умард Солонгос "террорист" гэсэн тодорхойлолтоос гарахын тулд зарим санал, санаачлага дэвшүүлж АНУ-тай үг хэлээ ололцох оролдлого хийж байна. Тухайлбал, БНАСАУ-ын дэд маршал, Умардын хоёрдахь удирдагч Чо Мен Рок өнгөрсөн оны аравдугаар сарын эхээр АНУ-д айлчилж Ерөнхийлөгч Клинтонтой уулзаж, Төрийн нарийн бичгийн дарга М. Олбрайтыг БНАСАУ-д айлчлахыг урилаа. Олбрайт ч урилгыг талархан хүлээн авч БНАСАУ-д айлчиллаа.

АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Ази тэр дундаа Солонгосын хойг, Умард Солонгосын талаар баримтлах бодлогоо тодорхойлсон. Түүнд "Умард Солонгосын талаар АНУ ямагт сэрэмжтэй байх ёстой ч Пхеньяны эрх баригчид Вашингтонтой хамтран ажиллахаа илэрхийлбэл АНУ хариу алхам хийх болно. Умард Солонгосын яриа хэлэлцээг АНУ бүрэн дэмжиж байгаа бөгөөд Пхеньян цөмийн зэвсгийн хөтөлбөрөө зогсоовол АНУ цөмийн эрчим хүчний шинэ үйлдвэр барих 1994 оны гэрээг чанд мөрдөх болно" гэж тов тод тодорхойлсон¹².

Умард Солонгосын Ерөнхийлөгч Ким Чен Ир энэ оны

нэгдүгээр сарын сүүлчээр БНХАУ-д айлчилж Хятад улсын дарга Зян Зэминь-тэй уулзах үеэр АНУ, Япон зэрэг оронтой харилцаагаа сайжруулах шаардлагатай байна гээд "Хүйтэн дайны сөргөлдөгч талуудын харилцаа холбоог сайжруулах үүднээс АНУ-ын Ерөнхийлөгч Буштай уулзах хүсэлтэй байгаагаа" илэрхийлсэн байна¹³. Энэ бүхэн нь дэлхий нийт Умард Солонгосыг аюул занал мэт үздэг үзлээс нь салгахад чиглэсэн Умардынханы хийж буй оролдлого гэж үзэж болох юм. АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Жорж У. Буш цөмийн зэвсэгтэй орнуудын пуужингаас хамгаалахын тулд тусгай хаалт (бамбай) барих төлөвлөгөөг нэн тэргүүнд тавих тухай түүний туслахууд мэдэгдсэн. Харин Умард Солонгос Америкийн баруун эрэг хүрч чадахуйц пуужин туршсан билээ. Хятадын хувьд гэвэл Зүүн хойд Азид иймэрхүү асуудал дэлгэрэхээс эрс болгоомжилж буй нь Тайван зэрэг оронд нөлөөлөх бий хэмээснийх юм. Тиймээс ч Умард Солонгосын дипломат харилцааг дэмжиж, Солонгосын хойг дахь цөмийн пуужингийн тархалт, зэвсэглэлээр хөөцөлдөхийн эсрэг байр суурь баримталж буй билээ.

БНАСАУ-ын удирдагч Ким Чен Ир-ийн БНХАУ-д хийсэн 6 өдрийн айлчлалын гол зорилго нь улс төрийн хувьд ижил системтэй, он удаан жил найрсаг харьцаатай явж ирсэн хуучин андынхаа эдийн засгийн шинэчлэлийн үйл явцтай нарийвчлан танилцаж, улс орныхоо эдийн засгийг гадаадын хөрөнгө оруулалт, дэвшилтэд технологийн өмнө хэрхэн нээлттэй байлгах талаар туршлага хуримтлуулах зорилготой байсан хэмээн ажиглагчид дүгнэсэн. Харин БНСУ-ын Ерөнхийлөгч Ким Дэ Жүн Ким Чен Ир-ийн айлчлалын тухайд "Умард Солонгос хоёр дахь Хятад болохыг хүсч байна" гэжээ¹⁴. Хөгжлийн туршлага, бусад олон хүчин зүйлсээрээ Хятадаас хол тасархай яваа элэг нэгт ахан дүүсээ дагах уу? Үзэл суртлын үнэнч зөвлөх Хятадаа дагах уу? гэдэг энэ эгзэгтэй, асар их ач холбогдолтой асуудалд хариу өгөх хариуцлагатай мөч Пхеньянд тулж ирлээ. Магад ч үгүй тэд эхийн эцээж тугалыг нь тураахгүйн үүднээс тэр хоёрын дундач холимог хувилбарыг нэг хэсэгтээ сонгохыг ч үгүйсгэх аргагүй. Юу боловч үүнийг цаг хугацаа харуулах бизээ.

Шинэ зууны эхний гадагш айлчлах гараагаа Хятадаас эхэлсэн Ким Чен Ир энэ оны тэргүүн хагаст багтаж ОХУ, БНСУ-д айлчилна гэж гаднын мэдээллийн агентлагууд уламжлав. Эхлээд алинд нь айлчлах нь одоогоор таамаг хэвээр байна. Ажиглагчдын үзэж буйгаар бол эхлээд БНСУ-д айлчлах аж.

НҮБ болон олон улсын ажиглагчид, шинжээчдийн үзэж байгаагаар БНАСАУ юу боловч гадагшаа нээлттэй болох бэлтгэл ажлаа хангаж буй гэнэ. Тус орны хувьд нээгдэнэ гэдэг ойлголт харьцангуй ойлголт. Учир нь нэн хаалттай энэ орон жинхэнэ утгаараа нээлттэй болж тавьсан зорилтоо хэрэгжүүлэхэд урт удаан зам туулах

болно. Умард Солонгос дахь өнөөгийн үйл явцыг тодруулбал, Умард Солонгосын нээгдэх үйл явцад тулгарч буй хүнд бэрх, хамгийн том дийлдэшгүй бул хар чулуу болон хамаг зүйлд нь хаалт саад болж буй зүйл бол тоталитар тогтолцоо, асар их амь бөхтэй хэвшин тогтсон хараа хяналт, удирдлагад бүрэн төвлөрсөн шийдвэр гаргах эрх мэдэл юм. Гэсэн хэдий ч дэлхий нийтийн хөгжлийн жишиг хандлага, олон улсын харилцааны стандартыг хүлээн зөвшөөрч, гадаад бодлогынхоо үзэл баримтлалыг шинэчлэхийг эрмэлзэж буй нь Пхеньяны хувьд бага зүйл биш, урагш харсан нэг алхам гэж үзэх нь зүйд нийцэх бизээ. Нөгөө талаар хоёр солонгосын хамтын ажиллагааны өрнөл нь БНАСАУ АНУ-тай хэрхэн харилцахаас ихээхэн хамааралтай байх бизээ.

Дээрхи үйл явцыг хураангуйлан, Солонгосын хойгийн байдал нэг үеэ бодвол харьцангуй тогтворжиж, Умард, Өмнөдийн хоёр талын хэлхээ холбоо, хамтын ажиллагаа асар богино хугацаанд төр засгийн дээд түвшинээс эхлээд эдийн засаг, нийгмийн амьдралын бараг бүх хүрээг хамарч эрчимтэй өрнөж байна гэж үзэж болох юм. Ялангуяа хувийн хэвшил, олон нийтийн байгууллага, соёл, урлаг, спорт, эрдэм шинжилгээний байгууллагуудын хүрээн дэх хамтын ажиллагаа алхам алхмаар өргөжсөөр байна.

Эвлэрэл, энхийн хамтын ажиллагаанаас өөр ухаалаг сонголт байхгүй болохоор хүссэн хүсээгүй улам бүр глобальчлагдан буй өнөөгийн ертөнцөд энх тайвнаар зэрэгцэн оршиж, хамтарч ажиллах, улмаар аль алиныхаа эрх ашиг, эрхэм зорилгодоо нийцүүлэн, арга хэлбэрээ олж, нэгэн хойгийн нэгэн үндэстэн нэгдмэл хүчирхэг улс болж XXI зууны эхний түүхэнд орох нь дамжиггүй. Чухамхүү тийм ч учраас Норвегийн Нобелийн шагнал олгох комисс БНСУ-ын Ерөнхийлөгч Ким Дэ Жүний Солонгос болон Зүүн Азийн ардчилал, хүний эрхийг хөгжүүлэх, ялангуяа "Нарны элч" бодлогоороо ар Солонгостой энх тайван, эвлэрлийн харилцааг тогтооход жинтэй хувь нэмэр оруулсан гавьяаг нь онцлон үнэлж өнгөрсөн зууны сүүлчийн Нобелийн энх тайвны шагналын эзэнээр түүнийг тодруулсан.

Монголын төр засаг, ард түмэн Солонгосын хойгийн эвлэрэл, хамтын ажиллагаа болон энх тайвныг цогцлуулахын төлөө явуулж буй Өвөр Солонгосын Ар Солонгосын талаархи Нарны элч бодлогыг дэмжиж, сүүлийн үед Солонгос хоорондын харилцаанд гарч буй нааштай ахиц өөрчлөлт бүхнийг анхааралтай ажиглан харж, энэ бүхэн Монголд ч хамаатай хэмээн үзэж, түүнийг чин сэтгэлээсээ талархан дэмжиж ирсэн билээ. Түүнчлэн энэ бүхэн нь ар өвөр Солонгосын хамтын хүчин чармайлт, дэлхий нийтийн тусламж дэмжлэгийн үр дүн хэмээн өндрөөр үнэлж үздэг юм.

Ашигласан материал:

1. Facts about Korea, Seoul, 1998,
2. Страны мира/ энциклопедический справочник/ Минск, 2000 г. стр. 600
3. "Өдрийн сонин", 2000. 06.13
4. Мөн сонин, 2000. 08. 15
5. Мөн сонин, 2000. 06. 17
6. Мөн сонин, 2000. 09. 19
7. Мөн сонин, 2000. 09. 30
8. "Өнөөдөр" сонин, 2000. 01. 27
9. "Өдрийн сонин", 2000. 09. 21
10. Мөн сонин, 2000. 06. 21
11. Мөн сонин, 2000. 10. 26
12. Мөн сонин, 2001. 01. 26
13. Мөн сонин, 2001. 01. 23
14. Мөн сонин, 2001. 01. 24

Өгүүлэлд интернетийн мэдээллийн сүлжээг өргөн ашиглав.